

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН 2 -Р БАГИЙН 3 ДУГААР СУРГУУЛИАС ХҮНД
ДААЦЫН АВТО ЗАМ ХҮРТЛЭХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ /306 М/
АЖЛЫН ДААЛГАВАР**

2019 оны 03-р сарын 01 -ны өдөр

Замын-Үүд сум

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Замын-Үүд сумын 2 –р багийн 3 –р сургуулиас хүнд даацын авто зам хүртлэх 306 м хатуу хучилттай авто зам шинээр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.

А. Ажил гүйцэтгэх хугацааны график төлөвлөгөө (хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүч, машин механизмын тоо) тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи ажлын аргачлалыг гаргаж ирүүлнэ.

Б. “Авто зам барих барилгын норм” БНБД 32-02-00, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, “ Хот суурин төлөвлөлтийн норм ба дүрэм” П-60-75, Барилга байгууламжийн инженер судалгааны нийтлэг үндэслэл болон бусад холбогдох Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

В. Зураг төсвийн үнэ 6 500 000 /дөрвөн сая төгрөг/ -ийг тусгаж өгнө.

Авто замын барилгын ажил:

- Авто замын барилга угсралтын ажлыг ажлын тоо хэмжээний дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.
- Ажлыг гүйцэтгэхдээ талбайн хэмжилт, гадаслагаа зэргийг зурагт заагдсан координат трассын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- Авто замын барилга угсралтын ажлыг авто зам барих ажлын технологийн дарааллын дагуу гүйцэтгэнэ.
- Бульдозероор ургамлын үеийг хуулан ул хөрсийг тэгшлэн нягтруулалтыг техникийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.
- Техникийн шаардлагын дагуу далангийн дүүргэлт, суурийн доод үеийн материалыг тарааж тэгшлэн нягтруулна.
- Цементээр бэхжүүлсэн суурин дээр битумыг жигд цацсны дараа техникийн шаардлагын дагуу халуун асфальтбетон хольцыг хоёр үеэр дэвсэж нягтруулна. Бүрэн нягтруулалтын дараах хучилтын зузаан $h=50$ мм байна.
- Ус зайлуулах хоолойг зургийн дагуу хийж гүйцэтгэсэн байна.
- Авто замын хэвтээ тэмдэглэгээг болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдгийг техникийн шаардлагын дагуу хийж байрлуулна.

Тендерийн материалд тавигдах шаардлага:

- Ажилчдын тарифт цалинг ЗТБХБ-ын сайдын 2009 оны 263 дугаар тушаалын дагуу, нэмэгдэл цалинг ЗТАЖ-ын сайдын 2007 оны 11 сарын 20-ны өдрийн 187 тоот тушаалын дагуу ИТА, жолооч, механизмчин, замын ажилчдын нийт цалингийн 15,1%-иар бодож төсөвт тусгах.

- Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 зүйлд заасны дагуу ажил олгогч /компани/-ийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зам барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер, техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 10%-иар, Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын дагуу “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал”-ын шимтгэлийн хувь хэмжээг 3%-иар /нийтдээ 13%/ тус тус тооцох.

- ЗТАЖ-ын сайдын 2007 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 187 тоот тушаалын дагуу удирдлагын зардлыг нийт цалингийн сангийн 63,5%-иар, ашгийн хэмжээг цалингийн сангийн 71,8%-иар тооцох.

- Автомашингаар ачаа тээвэрлэх зардлыг ЗТАЖ-ны сайдын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 136 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифын дагуу, машин механизмын ажлын нэгж

маш.цагийн зардлыг ЗТБХБ-ын сайдын 2010 оны 275 тоот тушаалаар батлагдсан “Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнэ”-ийн дагуу тус тус тооцох.

- Захиалагчийн хяналтын зардлыг төсвийн 2%, зохиогчийн хяналтын зардлыг Захиалагчийн хяналтын зардлын 1%, магадалшгүй ажлын зардлыг 2%, нэмэгдсэн өртгийн албан татварыг “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 11-р зүйлийн 11.1-р заалтын дагуу барилга угсралтын ажлын зардлын 10%-иар тооцож төсөвт тусгах.

- Норм, нормативын санг 0.4%-иар тооцно.

- Авто зам, замын байгууламжийн барига угсралтын ажлын мэргэшсэн инженертэй байх.

Ажлын тоо хэмжээ

Д/д	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Бэлтгэл ажил			
1	Замын чигийг сэргээх	1км	0.306
2	Зам доогуурх болон дагуу байршиж буй шилэн кабель зайлуулах	1км	0.4
3	Зам доогуур дулааны шугамын 1.5 м * 80 см хэмжээтэй суваг байгуулах	1 у/м	12
Газар шорооны ажил			
4	Ул хөрсийг тэгшлэж нягтруулах	1м3	292.5
5	Зөөврөөр далан байгуулах	1м3	401.6
6	Экаскаватораар хөрс ухаж ачих	1м3	536.2
Хучилтын ажил			
7	Хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах h=0.3 м	1м3	585
8	Зохист ширхэглэл бүхий дайрган суурь байгуулах h=0.20 м	1м3	390
9	Жижиг ширхэгтэй асфальтбетон хучилт байгуулах h=0.05 м	1м3	97.5
10	Замын хашлага тавих	1 у/м	625
Явган хүний замын ажил			
11	Явган хүний замын хашлага тавих	1 у/м	640
12	Явган хүний замын суурийг элс хайрганы хольцоор хийх	1м3	63.91
13	Цементбетон хольцоор явган зам хийх	1м3	63.91
14	Тусгаарлах зурвасыг зүлэгжүүлэх	10м2	1.6
15	Хайрган хөвөөг гар аргаар байгуулах	1м3	30.6
Замын тоноглол			
16	Замын тэмдэг суурьлуулах	1ш	1
17	Замын тэмдэглэгээг зориулалтын машинаар хийх	1м	306